

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН СОНГУУЛЬ 2024

### ЧӨЛӨӨТ ШУДАРГА СОНГУУЛИЙН ЗАРЧМУУДЫГ ХӨНДСӨН ЗАРИМ АСУУДАЛ

#### Оршил

2024 оны Монгол Улсын Их Хурал (УИХ)-ын ээлжит сонгуулиар 126 гишүүнтэй анхны парламентыг бүрдүүлсэн нь орчин цагийн улс төрийн түүхэнд тодоор тэмдэглэгдэх онцлог үйл явдал байв. 2023 онд Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлт, түүнийг дагалдуулан УИХ-ын сонгуулийн тухай хуульд туссан нэмэлт, өөрчлөлтөөр УИХ-ын 126 гишүүний 78-ыг олныг төлөөлөх (мажоритар) аргаар, 48-ыг хувь тэнцүүлэн төлөөлөх (пропорциональ) аргаар буюу сонгуулийн холимог тогтолцооны зэрэгцээ хувилбарыг тусган хуульчилсан билээ. Улмаар 2024 оны 6-р сарын 28-ны өдөр явагдсан сонгуульд нийт 19 нам, 2 эвсэл оролцож, ардчилсан сонгуулийн түүхэнд хамгийн олон буюу 1341 нэр дэвшигч өрсөлдөв. Тэдний 372 нь намын жагсаалтаар, 969 нь тойргуудад өрсөлдсөн бөгөөд тойрогт нэр дэвшигчдийн 42 нь бие даан нэр дэвшигч байлаа. Сонгогчдын нэрийн жагсаалтад бүртгэгдсэн нийт 2,089,939 сонгогчийн 1,448,300 нь буюу 69.4 хувь нь

саналаа өгсөн нь 2020 оны цар тахлын үеэр зохион байгуулсан УИХ-ын сонгуулийн 73,64 хувийн ирцээс буурсан, ардчилсан сонгуулийн түүхэнд сонгогчдын ирц 70 хувьд хүрээгүй хоёр дахь удаагийн сонгууль болов.<sup>1</sup>

Санал хураалтын турш сонгогчдын ирцийн мэдээллийг хүйс болон насны ангиллаар нарийвчлан шууд дамжуулан олон нийтэд мэдээлж байсан нь энэ удаагийн ээлжит сонгуулийн зохион байгуулалтад гарсан чухал дэвшил байлаа. Сонгуулийн тогтолцооны шинэчлэл, автомат машинаар тоолсон саналын хуудсыг бүх хэсгийн хороонд гараар дахин тоолж тулгах гэх мэт хуульд тусгасан өөрчлөлттэй холбоотой санал хураалтын дүн хожуу гарах вий гэсэн болгоомжлол байсан ч сонгуулийн өдөр ийм бэрхшээл тохиолдоогүй.

Түүнчлэн сонгуулийн үр дүнд бүрэлдсэн 126 гишүүн бүхий парламентад 32 нь буюу 25 хувь нь эмэгтэй гишүүн байгаа нь дэлхийн дундаж болох 27 хувьд ойртсон, Ази тивийн улсуудын

<sup>1</sup> Монгол Улсын Сонгуулийн ерөнхий хороо

парламентад эмэгтэйчүүдийн эзлэх 22 хувийн дунджаас харьцангуй өндөр үзүүлэлт байгааг онцлон дурдах нь зүйтэй.<sup>2</sup>

Ийнхүү дэвшил гарсан хэдий ч чөлөөт, шударга сонгуулийн зарчмаас хазайсан,

цаашид сонгуулийн легитим чанарыг бэхжүүлж хамгаалахын тулд анхаарч үзэх, сайжруулах шаардлагатай зарим асуудал ажиглагдсаныг энэхүү тайланд тоймлон танилцуулж байна.

## **Нэг. Сонгуулийн тогтолцоо ба тойрог, мандаттай холбоотой асуудлууд**

### **1.1 Сонгууль тэгш байх зарчим: тойрог байгуулах үйл явц**

УИХ-аас 2023 оны 12-р сарын 21-нд гаргасан 112-р тогтоолоор сонгуулийн мажоритар тойргуудыг бүсчилсэн байдлаар буюу 2-10 мандаттай 13 тойрог байхаар шийдвэрлэсэн билээ. Мажоритар 78 мандатын 54 нь орон нутгийн 7 тойрогт, 24 нь нийслэлийн 6 тойрогт ногдож байна. 2020 оны сонгуультай харьцуулахад нийслэлийн сонгогчдын тоо нийт сонгогчдын 44.7 хувиас 47.1 хувь

болж өсжээ. Харин хуулийн шинэчлэлийн үр дүнд 76 мандат дээр нэмэгдсэн 2 мандатыг сонгогчдын тоо өссөн нийслэлд бус орон нутгийн тойргуудад хуваарилсан нь сонгуулийн тойрог байгуулахад баримтлах ёстой Монгол Улсын соёрхон баталсан олон улсын эрх зүйн баримт бичгүүдээр баталгаажсан шударга сонгуулийн тэгш эрхийн зарчимд нийцэхгүй байна.<sup>3</sup>

### **УИХ-ын 2024 оны ээлжит сонгуулийн тойрог, мандат, сонгогчдын тоо**

Тойрог	Засаг захиргааны нэгж	Сонгогчдын тоо	Хүн амын тоо	Мандатын тоо	Нэг мандатад ногдох сонгогчдын тоо
1	Архангай	59474	94318	9	20851
	Баянхонгор	55224	88967		
	Өвөрхангай	72965	116323		
2	Говь-Алтай	37125	57555	10	19209
	Завхан	46581	46839		
	Увс	53507	85505		
	Ховд	54886	91892		
3	Баян-Өлгий	62809	116191	3	20936
4	Булган	39312	60700	8	24111
	Орхон	67523	110052		
	Хөвсгөл	86053	137829		

<sup>2</sup> Парламентад эмэгтэйчүүдийн эзлэх хувь. Олон улсын парламентын холбоо. 2025 оны 1-р сарын байдлаарх статистик <<https://data.ipu.org/women-averages/>>

<sup>3</sup> НҮБ-ын Иргэний болон Улс Төрийн Эрхийн тухай Олон Улсын Пакт болон НҮБ-ийн Хүний эрхийн хорооны 1996 оны 57-р чуулганаар баталсан 25 тоот ерөнхий тайлбарын 21 дэх хэсэг

Тойрог	Засаг захиргааны нэгж	Сонгогчдын тоо	Хүн амын тоо	Мандатын тоо	Нэг мандатад ногдох сонгогчдын тоо
5	Дархан-Уул	65026	109312	10	19339
	Сэлэнгэ	67706	107906		
	Төв	60666	95045		
6	Дорнод	51933	84350	7	20488
	Сүхбаатар	41385	65760		
	Хэнтий	50104	80010		
7	Говьсүмбэр	10431	17942	7	18864
	Дорноговь	44148	71391		
	Дундговь	29431	46314		
	Өмнөговь	48039	76581		
<b>Улаанбаатар</b>					
8	Баянзүрх	249521	436198	5	49904
9	Баянгол	145846	260404	3	48651
10	Сүхбаатар	91204	159227	6	30519
	Чингэлтэй	91911	156344		
11	Сонгинохайрхан	203691	352162	5	40738
12	Хан-Уул	157561	281477	3	52250
	Багануур	18251	30146		
	Багахангай	2770	4613		
13	Налайх	24866	42165	2	22943

Монгол Улс НҮБ-ын Иргэний болон Улс Төрийн Эрхийн тухай Олон Улсын Пакт (ИБУТЭОУП)- ад 1968 онд гарын үсэг зурж, 1974 онд соёрхон баталсан. Энэхүү пактын 25-р зүйлд төрийн үйл хэрэгт оролцох, сонгуулийн эрх, тэгш эрхийн ерөнхий нөхцөлтэйгөөр улс төрийн алба хаших эрх чөлөөг баталгаажуулсан байх бөгөөд энэ талаар НҮБ-ийн Хүний эрхийн хорооны 1996 оны 57-р чуулганаар баталсан 25 тоот ерөнхий тайлбарын 21 дэх хэсэгт "пактад сонгуулийн тодорхой тогтолцоог заагаагүй ч Гишүүн улсын сонгосон аливаа сонгуулийн тогтолцоо нь 25-р зүйлээр хамгаалагдсан

эрхэд нийцэх ёстой бөгөөд сонгогчдын чөлөөтэй илэрхийлсэн хүсэл зоригийг амилуулан, баталгаажуулбал зохино. Үүнд, "нэг сонгогч, нэг санал"-ын зарчим үйлчлэх ёстой ба гишүүн улсын сонгосон сонгуулийн тогтолцоонд нэг сонгогчийн өгсөн санал нөгөө сонгогчийн саналтай ижил тэнцүү жинтэй байна. Сонгуулийн нутаг дэвсгэрийг байгуулах, мандат хуваарилах аргачлал нь сонгогчдын тоо байршлаас гажуудаагүй, аливаа нэг бүлгийг ялгаварлан гадуурхаагүй, иргэдийн төлөөлөгчөө чөлөөтэй сонгох эрхийг үндэслэлгүй хязгаарлаж боогдуулахгүй байх ёстой" гэжээ.

УИХ-ын 2024 оны ээлжит сонгуулиар нийслэлд нэг мандатад ногдох сонгогчдын дундаж тоо 41,068 байсан бол орон нутагт 20,451 байна. Мажоритар тойрогт мандатад ногдох сонгогчдын тоог эн тэнцүү байхаар төгс хуваарилалт хийх боломжгүй. Гэвч хэт их зөрүүтэй байх нь ардчилсан сонгуулийн тэгш эрхийн зарчимд үл нийцнэ. 2024 оны УИХ-ын сонгуулийг ажигласан олон улсын ажиглагчдын тайланд дурдсанаар мандатын тоонд ногдох тойргийн сонгогчдын тооны зөрүү нь улсын голчоос 10-15 хувиас хэтрэхгүй байх стандартыг ардчилсан улсуудад удирдамж болгож байна. 2024 оны 6-р сарын байдлаар сонгогчдын нэрийн жагсаалтад бүртгэгдсэн сонгогчдын тоог үндэслэн энэхүү голчийг тооцон үзвэл УИХ-ын нэг гишүүн 26,794 сонгогчийг төлөөлөхөөр байна. Нийслэлийн тойргуудын хувьд улсын голчоос гажсан зөрүү нь 53 хувиар илүү байгаа бол хөдөөд 23.6 хувиар бага байна. Өөрөөр хэлбэл, нийслэлтэй харьцуулахад сонгогчдын тоо цөөрсөөр байгаа орон нутагт сонгогчдын саналын жин маш өндөр зөрүүгээр илүү байгаа нь харагдана. Тойргуудыг харьцуулж үзвэл мандатад ногдох сонгогчдын тоо 18,864-с 52,250-ын хооронд хэлбэлзэж байгаа нь сонгууль тэгш байх зарчим хэрэгжихгүй байгааг илэрхийлж байна.

УИХ-ын сонгуулийн тухай хуулийн 12.3-т зааснаар сонгуулийн тойргийг байгуулахад аймаг, дүүргийн хүн амын тоо, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн хуваарь, газар нутгийн хэмжээ, байршил зэргийг харгалзах бөгөөд хуулийн 12.4-т тойрогт хамаарах засаг захиргааны нэгж нь нутаг дэвсгэрийн хувьд нэгдмэл, хилийн цэсийн хувьд зэргэлдээ байх шаардлагыг тусгажээ. 2024 оны УИХ-ын сонгуулийн тойргуудыг байгуулсан байдлыг үзвэл бүсчилсэн байдлаар зохион байгуулсан нь засаг захиргаа, нутаг

дэвсгэрийн нэгж, газар нутгийн байршлыг гол үзүүлэлт болгосон нь илэрхий, харин хүн амын тоо, үүнд иргэд хот суурин газарт шилжин суурьших нүүдэл буурахгүй байсаар ирсэн хандлагыг тооцож үзээгүй болох нь харагдана.

Монгол Улс өргөн уудам газар нутагтай нь мандатыг тэнцвэртэй хуваарилахад бэрхшээл учруулдаг гэх тайлбар байдаг ч олон улсын мэргэжилтнүүдийн зүгээс энэ асуудлыг төсвийн хуваарилалт гэх мэт механизмуудаар шийдэх бололцоотой гэж шүүмжилдэг.

Сонгуулийн тойрог нь сонгуулийн тогтолцооны гол бүрэлдэхүүн бөгөөд тойргийг хэрхэн байгуулах нь сонгуулийн үр дүнд шууд нөлөө үзүүлэх ач холбогдолтой тул сонгууль бүрээр шинээр байгуулах нь тогтолцоог дахин дахин өөрчилсөнтэй ижил үр дагавартай юм.

Иймд УИХ-ын сонгуулийн тухай хуулийн 12.1-д “Улсын Их Хурал ээлжит сонгуулийн жилийн 02 дугаар сарын 01-ний өдрөөс өмнө сонгуулийн тойрог /цаашид "тойрог" гэх/-ийг байгуулна” гэснийг цаашид өөрчлөх шаардлагатай. Бүс нутгийн бусад ардчилсан улсын туршлагыг үзвэл Энэтхэг Улсад 10 жил тутамд явагддаг хүн амын тооллогын дараа бие даасан хороо байгуулж сонгуулийн тойргуудыг шинэчлэх эсэх асуудлыг шийдвэрлэхээр хуульчилсан байдаг ба 1950 оноос хойш сонгуулийн тойргууд нь үндсэндээ өөрчлөгдөөгүй, тогтвортой хэвээр байна. Филиппин Улсад мөн хүн амын тооллого явагдсанаас хойш гурван жилийн дотор тойргуудын шинэчлэх эсэх асуудлыг авч үздэг бөгөөд мөн тойргууд нь тогтвортой байсаар иржээ. Австрали Улсад сонгуулийн тойргуудын 1/3-д мандатад ногдох сонгогчдын тоо улсын голчоос 10 хувиас

хэтэрсэн бол статистикийн мэргэжилтэн оролцсон бие даасан хороо байгуулж олон нийтийн оролцоотой сонгуулийн тойргуудыг шинэчилдэг.<sup>4</sup>

Цаашид сонгуулийн тойргийг байгуулах, тойрогт ногдох мандатын тоог тогтоохдоо

УИХ-ын олонх шийдэх бус олон улсын сайн туршлагыг даган бие даасан, мэргэжлийн хороо байгуулж, сонгогчдын саналыг тусган ил тод шийдвэрлэдэг болох нь сонгуулийг шударга явуулахад дөхөмтэй болно.<sup>5</sup>

## 1.2 Сонгогч саналаа чөлөөтэй гаргах зарчим: мандатын тоогоор санал өгөх зохицуулалт

Сонгогчдын саналд үндэслэн парламентын суудал хуваарилахад шууд нөлөөтэй бөгөөд энэ утгаараа сонгуулийн тогтолцоо хэмээх цогц ойлголтын бас нэг чухал бүрэлдэхүүнд тооцогддог асуудал бол сонгогч санал өгөхтэй холбоотой зохицуулалт байдаг.

УИХ-ын сонгуулийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.1 дэх хэсэгт тойрогт ногдсон мандатын тооноос...дутуу нэр дэвшигчийн төлөө санал тэмдэглэсэн саналыг хуудсыг хүчингүйд тооцохоор заасан нь ардчилсан сонгуулийн "чөлөөтэй" санал гаргах зарчимд нийцэхгүй байна. Дээр өгүүлсэнчлэн 2024 оны УИХ-ын ээлжит сонгуулийн олонхын зарчмаар суудал хуваарилсан 13 тойрог нь 2-10 мандаттай байсан. Эдгээр мандатаас доош тооны нэр дэвшигчийг дэмжих саналтай сонгогч саналын хүүдсаа хүчинтэйд тооцуулахын тулд дэмжихийг хүсээгүй зарим нэр дэвшигчийг нэмж санал тэмдэглэхээс өөр аргагүй байдалд хүрж байна. Энэ нь сонгуулийн эцсийн үр дүн сонгогчдын хүсэл зоригийн жинхэнэ илэрхийлэл байх нөхцөлийг хангахгүй байна.

Монгол Улсын Үндсэн хуульд сонгогч саналаа чөлөөтэй гаргах үндсэн эрхийг 21 дүгээр зүйлийн 2-д "Улсын Их Хурлын гишүүнийг Монгол Улсын сонгуулийн эрх бүхий иргэд нийтээрээ, чөлөөтэй, шууд сонгох эрхийн үндсэн дээр саналаа нууцаар гаргаж, дөрвөн жилийн хугацаагаар сонгоно" гэж тодорхой зааж баталгаажуулсан байна.

НҮБ болон бусад нэр хүнд бүхий олон улсын байгууллагуудаас гаргасан тайлбаруудаас үзэхэд чөлөөт сонгууль нь сонгогч тодорхой нэр дэвшигч, нам, эвслийн төлөө саналаа өгөх, эсхүл өгөхгүй байх шийдвэрээ нууцаар, хөндлөнгийн аливаа нөлөөлөл сүрдүүлгээс ангид, айж эмээлгүй гаргаснаар хэрэгжинэ.<sup>6</sup> Санал нууц байх ардчилсан сонгуулийн зарчим нь сонгогч чөлөөтэй сонголт хийх нөхцөлийг бүрдүүлж, улмаар сонгуулийн үр дүн сонгогчдын хүсэл зоригийн жинхэнэ илэрхийлэл байх баталгааг хангах зорилго агуулдаг.

Эцэст нь дүгнэвэл, сонгогч тодорхой нам, эвсэл, нэр дэвшигчид саналаа өгөхгүй байх эрх нь чөлөөтэй сонголтын нэг хэлбэр мөн.

<sup>4</sup> Азийн чөлөөт сонгуулийн төлөө сүлжээ. 2023. <https://anfrel.org/regional-roundtable-concluded-with-the-kuala-lumpur-declaration-on-apportionment-and-boundary-delimitation/>

<sup>5</sup> Declaration on criteria for free and fair elections Unanimously adopted by the Inter-Parliamentary Council at its 154th session (Paris, 26 March 1994)

<sup>6</sup> Сонгуулийн олон улсын стандартууд. НҮБ-ийн Хүний эрхийн хорооны 25-р ерөнхий зөвлөмж 19-р догол мөр

International Standards of Elections UN Committee on Human Rights, General Comment 25,

"The Right to Participate in Public Affairs, Voting Rights and the Right to Equal

Access to Public Service," 1510th meeting (fiftyseventh session) (12 July 1996) <<https://www.osce.org/files/f/documents/4/a/19154.pdf>>

## Хоёр. Сонгогдох эрх: сонгуульд оролцох босго, тэгш гараа

### 2.1. Нэр дэвшихэд тавигдах босго (нам нэр дэвшигчдээ тодруулах процесс)

2019 онд Үндсэн хуульд туссан нэмэлт, өөрчлөлтийн хүрээнд “Намын дотоод зохион байгуулалт ардчилсан зарчимд нийцсэн, хөрөнгө орлогын эх үүсвэр, зарцуулалт нь нийтэд ил тод байна. Намын зохион байгуулалт, үйл ажиллагааны журам,

санхүүжилт, төрөөс санхүүгийн дэмжлэг үзүүлэх нөхцөлийг хуулиар тогтооно” гэж тусгасан (МҮҮХ-ийн 19’). Намын дотоод ардчиллыг илэрхийлэх гол үзүүлэлтийн нэг нь нэр дэвшигчдээ тодруулах процесс юм.

Намын дотоод ардчиллын асуудлыг судлаачид авч үзэхдээ юуны түрүүнд намын удирдлага, нэр дэвшигчдийг тодруулж сонгох процесс, намын хөтөлбөр, бодлогын байр суурийг тодорхойлох үйл явц, эдгээрт 1) гишүүдийн болон бусад талын оролцоог ямар түвшинд хангаж буй, 2) шийдвэр гаргах тогтолцооны төвлөрсөн байдал болон 3) институтчилэл хэрхэн хангагдаж байгааг шинжилж үздэг (Үндэсний ардчиллын хүрээлэн, 2005). Үүнд:

- Нээлттэй, оролцоо хангасан байдал: Шийдвэрээс өмнөх процесс буюу намын гишүүд, дэмжигчид, бусад оролцогч талуудыг сонсох, зөвшилцөх, шийдвэр гаргахад тэдний ямар жин дардаг болохыг энэ хэмжүүрээр дүгнэнэ. Оролцоо туйлын хязгаарлагдмал нөхцөлд нэг буюу нэг хэсэг удирдагчдын хүрээнд чухал шийдвэрүүд гарах ба бусад тал оролцох боломжгүй.
- Төвлөрсөн байдал: Шийдвэр ямар хүрээнд гарч байгааг энд авч үзнэ. Төвлөрсөн удирдлагатай намын гүйцэтгэх төв байгууллага нь гол шийдвэрүүдийг гаргаж, нам нь хүлээн авч дагадаг.
- Институтчилэл: Шийдвэр гаргах үйл явцыг журамлаж, албан ёсны болгон зохицуулсан байдал болон тэдгээрийг дагаж мөрдөх тогтолцоог үүнд хамруулан үзнэ.

Үндсэн хуульд туссан дээрх өөрчлөлтийн хүрээнд 2023 онд шинэчилсэн УИХ-ын сонгуулийн хуулийн тухайд холимог тогтолцоогоор сонгуулийг зохион байгуулах асуудлыг нарийвчлан зохицуулсны дотор хувь тэнцүүлэн төлөөлөх аргаар сонгох 48 суудлын төлөө өрсөлдөх намын жагсаалтын нэр дэвшигчдийг 1:1 хүйсийн харьцаатай байх шаардлагыг тусгасан байна.

2023 оны УИХ-ын сонгуулийн дээрх шинэчлэл нь ямар бодитой үр дүн үзүүлсэн бэ? гэх асуулт зүй ёсоор тавигдана. Ялангуяа, УИХ-ын суудлын тоо 76-с 126 болж нэмэгдсэнтэй холбоотой улс төр дэх мөнгөний зүй бус нөлөөнөөс ангид, олны итгэл хүлээх

чансаатай нэр дэвшигчид сонгуульд өрсөлдөх нөхцөл бүрэлдсэн үү? гэсэн асуулт сонгогчдын хувьд чухал асуултууд байв.

Сонгуулийн үр дүнд УИХ-д түүхэнд хамгийн олон буюу 32 эмэгтэй сонгогдсон нь юуны өмнө дээрх эрх зүйн шинэчлэлийн шууд үр дүн байлаа. Гэхдээ тойргоос сонгогдсон 78 гишүүний зөвхөн 8 нь эмэгтэй байгааг дурдах нь зүйтэй.

Сонгогдох эрхийг хангахад чухал оролцоотой институци болох улс төрийн намууд энэ удаагийн сонгуулиар Үндсэн хуульд туссан өөрчлөлтийг хэрэгжүүлэхэд идэвхтэй манлайлан оролцсонгүй. Сонгуулийн үр

дүнд УИХ-д зонхилох байр суурь эзлэх болсон намуудын нэр дэвшигчдээ тодруулах процесс нь намын цөөн тооны лидерүүдийн тохиролцоонд үндэслэн шийдэгддэг байдал давтагдав.<sup>7</sup> Нэр дэвшигчдээ тодруулах үйл явцад намын дотоод ардчиллын чухал үзүүлэлт болох намын гишүүдийн оролцоо, ил тод байдал илт үгүйлэгдэж байв. Зарим нэг намаас СЕХ-нд нэр дэвшигчдийн хоёр өөр жагсаалт хүргүүлэн маргаантай нөхцөл байдал үүсгэлээ. Ийнхүү УИХ-ын 2024 оны ээлжит сонгуулийн хувьд 2019 оны Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлтийн үр дүн

харагдсангүй гэж дүгнэж болохоор байна.

Цаашид 2023 онд шинэчлэн баталсан Улс төрийн намын тухай хуульд нийцүүлэн намууд гишүүдийн оролцоо, ил тод байдлыг хангасан, нэр дэвшигчдийг тодруулах явцад гарсан маргааныг хэрхэн шийдвэрлэх процессыг тодорхой тусгасан нэр дэвшүүлэх журмыг дагаж мөрдөх нь зүйтэй. Мөн намын дотоод ардчиллын зарчимд нийцүүлэн энэхүү журмаа гишүүддээ болон олон нийтэд ил тод болгоход анхаарвал зохино.

## 2.2. Нэр дэвшигчийг бүртгэхтэй холбоотой асуудал

Хуулиар тогтоосон дагуу сонгуульд оролцохоор бүртгүүлсэн 19 нам, 2 эвслээс тойрогт нэр дэвшүүлэхээр 985, жагсаалтаар нэр дэвшүүлэхээр 385, бие даан нэр дэвшигчээр 46, нийт 1416 хүний баримт бичгийг 2024 оны 5-р сарын 25-ны дотор СЕХ хүлээн авчээ. Улмаар СЕХ-ны 2024 оны

тавдугаар сарын 30 -ны хуралдаанаар УИХ-ын ээлжит сонгуульд нам эвслээс нэр дэвшүүлсэн 1206, бие даан нэрээ дэвшүүлсэн 39, нийт 1245 хүнийг нэр дэвшигчээр бүртгэж, үнэмлэх олгохоор шийдвэрлэсэн ба нэр дэвшигчид тавигдах шаардлага хангаагүй 154 хүнийг нэр дэвшигчээр бүртгэхээс татгалзсан билээ.<sup>8</sup>

Бүртгээгүй үндэслэл	Нэр дэвшигчдийн тоо
Татварын хугацаа хэтэрсэн өр төлбөртэй	76
Хуульд заасан баримт бичиг дутуу	63
Шүүхийн хүчин төгөлдөр тогтоолоор ял эдэлж байгаа	5
Нэр дэвшүүлсэн нам эвслээсээ өөр намын гишүүн	4
Сонгуулийн тойргоос 801-ээс доошгүй сонгогчдын гарын үсэг зуруулах шаардлага хангаагүй	4
Төрийн жинхэнэ албан хаагч хуулийн хугацаанд албан тушаалаасаа чөлөөлөгдөөгүй	1
Авлига, албан тушаалын гэмт хэрэг үйлдсэн нь шүүхээр тогтоогдсон	1

\*\* Мөн 17 хүн өөрсдөө нэр дэвшихээс татгалзсан аж

Ийнхүү татгалзсан шийдвэр хүлээн авснаас хойш хуульд заасан хугацаанд буюу 6-р сарын 2-ны дотор 102 нэр дэвшигч дахин

бүртгүүлэхээр Сонгуулийн ерөнхий хороонд хандсанаас 96-г нь бүртгэхээр шийдвэрлэжээ. СЕХ-ны нэр дэвшигчээр дахин бүртгэхээс

<sup>7</sup> Нэг дороос, МАН: Бага хурал дууссанаар, нэр дэвшигчдээ зарлахад бэлтгээд байна. 2024 <<https://eguur.mn/500328/>> Хүмүүнлэг ардчилсан зодоон. 2024 оны 5 сарын 21. <<https://itoim.mn/a/2024/05/21/analyze/zuu?48f9a0c701fa754be7564ad500b63261>>

<sup>8</sup> Монгол Улсын Сонгуулийн ерөнхий хороо



татгалзсан шийдвэр гаргасан бол тухайн шийдвэрийн талаар Захиргааны хэргийн шүүхэд нэхэмжлэл гаргах боломжтой бөгөөд энэ нөхцөлд тус шүүх тусгай журмаар буюу давж заалдах шүүх анхан шатны журмаар хянан шийдвэрлэх хуультай билээ. Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд сонгуулийг маргааныг 30 хоногийн дотор хянан шийдвэрлэх бөгөөд хугацааг нэг удаа 10 хүртэл хоногоор сунгаж болно гэж зохицуулсан байдаг. Гэтэл сонгуулийн

сурталчилгааны албан ёсны хугацаа 16 хоног байсан бөгөөд томсгосон тойргуудаар сонгуулийг зохион байгуулсан тул нэр дэвшигчдийн хувьд сонгогчдод хүрч мэдээлэл хүргэхэд дээрх хугацаа тун хангалтгүй байв.

Захиргааны хэргийн шүүхэд хандсан зарим нэр дэвшигчид үнэмлэхээ сонгуулийн албан ёсны сурталчилгааны хугацаа дуусах дөхсөн үед авсан бөгөөд<sup>9</sup> эдгээр нэр дэвшигчдийн хувьд сурталчилгаа явуулах боломж үндсэндээ байсангүй.

УИХ-ын сонгуулийн тухай хуульд “Нэг намын гишүүнийг өөр намаас, эвслийн тухайд түүнд нэгдэн орсон намуудаас өөр намын гишүүнийг нэр дэвшүүлэхийг хориглоно.” гэснийг үндэслэн Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуулиар нийт 4 нэр дэвшигчийг бүртгэхээс татгалзсан байх бөгөөд Сонгуулийн ерөнхий хорооны уг шийдвэрийг Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхээс хүчингүй болгож шийдвэрлэсэн байна. Улс төрийн намын тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн 5 дугаар зүйлийн 5.7-д “Намын гишүүн хэдийд ч өөрийн хүсэл зоригийн үндсэн дээр намаас гарах эрхтэй. Намын гишүүн намаас гарах тухай өргөдөл гаргаснаар түүнийг намаас гарсанд тооцно” гэж хуульчилсан. Иймд нэр дэвшигчид тавих дээрх тусгай шаардлагыг сонгуулийн тухай хуулиас хасах нь хуулийн нийцлийг хангах ач холбогдолтой гэж үзэж байна.

Цаашид сонгогдох эрхийг хангах үүднээс хуульд нэр дэвшигчдийг бүртгэхэд тавьж буй шаардлагыг олон улсын зарчмуудад нийцүүлэх, хэрэгжүүлэгч талуудад ойлгомжтой болгох, хуулийн тайлбар шаардлагатай нөхцөлд эрх бүхий этгээдээс гаргуулах ажлыг нэр дэвшигчийг бүртгэх үйл ажиллагаанаас

өмнө<sup>10</sup> зохион байгуулах арга хэмжээг СЕХ-ноос авах нь зүйтэй.

Түүнчлэн сонгуулийн маргаан шийдвэрлэх хугацааг сонгуулийн цагалбартай уялдуулан сонгох, сонгогдох эрхийг хангахуйц байдлаар зохицуулах шаардлагатай байна.

### 2.3. Сонгуульд оролцох намд тавигдах шаардлага (мөрийн хөтөлбөрийн аудит)

УИХ-ын сонгуулийн тухай хуулиар сонгуульд оролцох нам, эвсэл, нэр дэвшигчийн мөрийн хөтөлбөрт сонгогчдын саналыг татах зорилгоор эдийн засгийн үндэслэлгүй, хэрэгжих боломж багатай халамжийн үйлчилгээ, эдийн засгийн амлалт тусгахыг хориглодог. Энэ нь нэг талаар улс төрийн

клиентелизмийн нөлөө сонгуульд тусахаас сэргийлэх зорилготой арга хэмжээ боловч нөгөө талаас чөлөөт сонгуульд эрх бүхий нам, эвсэл, нэр дэвшигчид оролцох босгыг хэт өндөрсгөх, сонгууль үзэл бодлын чөлөөт өрсөлдөөний талбар байх нөхцөлийг үгүйсгэх эрсдэлтэйг судлаачид сануулсаар ирсэн.<sup>11</sup>

<sup>9</sup> Н.Хуланг Үндэсний эвслийн нэр дэвшигчээр бүртгэхийг СЕХ-нд даалгав <https://www.unuudur.mn/a/269078>

<sup>10</sup> ХУУЛЬЧИД: Н.Номтойбаяр нэр дэвших эрхтэй, эрхгүй <https://www.itoim.mn/a/2024/06/03/politic/btm?aae451e8b89948db70b9b5f713dda7bb>

<sup>11</sup> Монгол Улсын Их Хурлын 2016 оны ээлжит сонгуулийг ажигласан тайлан. Европын Аюулгүй Байдал Хамтын Ажиллагааны Байгууллагын Ардчиллын институци, Хүний эрхийн газар, 2016, хууд. 15



Ялангуяа, мөрийн хөтөлбөр хуульд тусгасан шаардлагад нийцэж буй эсэх талаар дүгнэлт гаргах чиг үүргийг хэрэгжүүлдэг Төрийн аудитын байгууллагыг тэргүүлж буй Ерөнхий аудиторыг томилох шийдвэрт эрх баригч нам давамгайлах нөлөөтэй оролцож, ил тод байдал хангалтгүй байгаа нөхцөлд дээрх эрсдэлийг нухацтай авч үзэн, цаашид зохих арга хэмжээ авах ёстойг 2024 оны ээлжит сонгууль харууллаа.<sup>12</sup>

2024 оны ээлжит сонгуулийг зохион байгуулах цаглаварын дагуу сонгуульд оролцох нам, эвсэл 3-р сарын 25, бие даан нэр дэвшигчид 4 сарын 25-наас өмнө төрийн аудитын дээд байгууллагад мөрийн хөтөлбөрүүддээ дүгнэлт гаргуулахаар хүргүүлсэн. Улмаар, аудитаас мөрийн хөтөлбөрүүдийг хянаж үзээд засуулахаар буцаасан шийдвэр гаргасан. Энэ шийдвэрийн талаар Ерөнхий аудиторын орлогч хэвлэлд өгсөн ярилцлагадаа дурдсаныг сийрүүлбэл:

“27 нам, хоёр эвслийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг буцаасан. Монгол Улсын эдийн засгийн урт хугацааны хөгжлийн зорилт, бодлогыг хангах, эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангах тооцооллуудыг үзэхэд засаж, залруулах зүйлс байгаа юм. Манай саналын дагуу нам, эвслүүд мөрийн хөтөлбөрөө эргэж харж, аудитын газарт 17-нд ирүүлнэ. Дөрөвдүгээр сарын 26-ныг хүртэл сонгуулийн мөрийн хөтөлбөрийг дахин хянаж, аудитын дүгнэлтээ гаргаад Сонгуулийн ерөнхий хороонд хүргэнэ.”<sup>13</sup>

Мөрийн хөтөлбөрийг буцаах үндэслэл нь УИХ-ын сонгуулийн тухай хуулийн 38.5-д заасан шаардлага буюу “Нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрт орсон зорилт, арга хэмжээ нь Монгол Улсын хөгжлийн урт хугацааны бодлогод нийцсэн эсэх болон санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын дүн нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан төсвийн тусгай шаардлагад нийцэж байгаа эсэх талаар төрийн аудитын байгууллагаар хянуулж дүгнэлт гаргуулсан байна” гэсэн зохицуулалт юм.

Улс төрийн клиентелизмийн нөлөө сонгуульд тусахаас сэргийлж мөрийн хөтөлбөрт аудит хийх зохицуулалт нь мөрийн хөтөлбөрт санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан арга хэмжээ тусгагдсан тохиолдолд түүнийг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын дүн нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан төсвийн тусгай шаардлагад нийцсэн эсэхийг хянах хүрээнд хэрэгжиж, улмаар энэ талаарх мэдээллийг сонгогчдод ил тод хүргэж, мэдээлэлтэйгээр санал өгөх нөхцөл бүрдүүлэхэд чиглэвэл ач холбогдолтой байж болох юм.

Харин одоо мөрдөж байгаа хуульд тусгасанчлан Монгол Улсын хөгжлийн урт хугацааны бодлогод нийцсэн эсэх асуудлыг хамрах нөхцөлд хяналтын хүрээ хэт өргөсөж улмаар чөлөөт сонгуулийн шалгуур үзүүлэлт болох үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх, олон ургалч байдлыг үгүйсгэх тал руу

<sup>12</sup> Ээлжит сонгууль болохоос өмнө буюу 2023 оны 12 дугаар сарын 28-нд Монгол Улсын Ерөнхий аудитор Д. Занданбат сонгуульд нэр дэвшихээ мэдэгдэн өөрийн хүсэлтээр үүрэгт албанаасаа чөлөөлөгдсөн. Түүний үүргийг орлон гүйцэтгүүлэхээр Ерөнхий аудиторын орлогчоор Д. Загджавыг томилсон бөгөөд УИХ-аас түүнийг Ерөнхий аудитораар томилох шийдвэрийг 2024 оны 5-р сард гаргасан. Төрийн аудитын тухай хуулийн 28.4-д “Монгол Улсын Ерөнхий аудиторын бүрэн эрхийн хугацаа дуусгавар болсон, эсхүл хугацаанаас өмнө чөлөөлсөн, огцруулсан бол Улсын Их Хурал энэ хуульд заасан журмын дагуу Монгол Улсын Ерөнхий аудиторыг 30 хоногийн дотор, чуулганы чөлөөт цагт бол ээлжит болон ээлжит бус чуулган эхэлснээс хойш 15 хоногийн дотор нөхөн томилно” гэж хугацааг тодорхой заасны дээр УИХ-ын Хяналт, шалгалтын тухай хуульд Ерөнхий аудиторыг томилоход нэр дэвшигчийн сонгол явуулах ёстой байв. Төрийн аудитын байгууллага, Ерөнхий аудиторын хараат бус ажиллах нөхцөлийг хангахад чиглэсэн дээрх хуулиудыг УИХ-аас томилгооны шийдвэр гаргахдаа ийнхүү баримтлаагүй болно.

<sup>13</sup> Үндэсний аудитын газраас 27 нам, хоёр эвслийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг буцаажээ. 2024-04-10. <<https://www.montsame.mn/mn/read/341509>>

халтирах эрсдэлтэй. Сонгуулийн утга учир нь бодлогоор ялгаатай талууд чөлөөтэй мэтгэлцэн өрсөлдөх талбар болох учиртай. Парламентын үнэмлэхгүй олонхын баталсан

хөгжлийн урт хугацааны бодлогод нийцэх мөрийн хөтөлбөртэй байх хуулийн шаардлага нь бодлогоор ялгарч өрсөлдөх боломжийг хязгаарласан шинжтэй байна.

### **Гурав. Өрсөлдөөний тэнцвэртэй орчин буюу тэгш гараа**

Энэ удаагийн ээлжит сонгуулийн сурталчилгаа нэр дэвшигчид үнэмлэх олгосон өдрөөс буюу 6-р сарын 10-наас эхлэн 6-р сарын 26-ныг дуустал цөөн хоног явагдав. Сонгуулийг бүсчилсэн том тойргуудад зохион байгуулсан нь сонгогчдод танигдсан, хөрөнгө нөөц илүүтэй нам, нэр дэвшигчдэд ээлтэй, энэ хэрээр өрсөлдөөний гарааны тэгш бус байдалд нөлөөлөх хандлага энэ удаагийн ээлжит сонгуулиар ахин давтагдлаа. Өмнө дурдсанчлан сонгуулийн тойргуудыг УИХ-аас ээлжит сонгууль бүрээр байгуулахаар зааж хуульчилсан нь сонгуулийн тогтолцооны чухал бүрэлдэхүүн хэсэг болох сонгуулийн тойргууд тогтворгүй байхад нөлөөлж, сонгуульд өрсөлдөгч талууд тодорхой тактик, төлөвлөгөөтэй кампанит ажлаа удирдан зохион байгуулах боломжийг хязгаарлах нөхцөл үүсгэж байгааг анхаарч хуульд зохих өөрчлөлтийг тусгах нь зүйтэй.

УИХ-ын сонгуулийн тухай хуулийн 41.9-д “Монгол Улсын Их Хурлын гишүүн сонгуульд нэр дэвшихээр бол хийсэн ажлын тайлангаа энэ хуульд заасан нэр дэвшүүлэх ажиллагаа эхлэхээс өмнө тарааж болох бөгөөд үүнийг сонгуулийн сурталчилгааны материалд тооцохгүй” гэж заасан. Түүнчлэн, хуулийн 44.6-д “Энэ хуульд заасан нэр дэвшүүлэх ажиллагаа эхлэхээс өмнө Улсын Их Хурлын гишүүн хийсэн ажлын тайлангаа танилцуулах зорилгоор сонгогчидтой хийсэн уулзалт болон энэ хуулиар хориглоогүй арга хэмжээ нь сонгогчдын санал татах зорилгоор явуулж байгаа үйл ажиллагаанд хамаарахгүй” гэжээ.

УИХ-ын гишүүд сонгогчдодоо ажлаа тайлагнах нь зүй ёсны асуудал боловч хуулийн дээрх заалтууд нь сонгуулийн жил сонгогдсон гишүүдэд давуу тал олгон тэгш гараанаас өрсөлдөх нөхцөлийг дордуулаад зогсохгүй сонгуулийн жил төрийн эх үүсвэрийг улс төрийн сурталчилгааны зорилгоор ашиглах нөхцөлийг бүрдүүлж байна. Ардчилал сонгуульд дэмжлэг үзүүлэх олон улсын хүрээлэнгийн 80 ардчилсан улсын хууль тогтоомжийг шүүн судалснаас үзэхэд зөвхөн Өмнөд Солонгос Улсын хуульд Үндэсний Ассамблейн гишүүн сонгогчдод ажлаа хэрхэн тайлагнах талаар зохицуулсан байдаг байна. Ингэхдээ сонгуулийн өрсөлдөөний тэгш гарааг хангах үүднээс санал хураахаас өмнөх 90 хоногт хэвлэмэл тайлан тараах, уулзалт зохион байгуулах зэргийг хориглодог ба зөвхөн цахим шуудан, өөрийн интернэт цахим хуудсаар дамжуулж тайлагнахыг зөвшөөрдөг ажээ.<sup>14</sup> Энэтхэг Улсын хуулиар парламентын гишүүд албан томилолтыг сонгуулийн сурталчилгаатай зэрэгцүүлж ашиглахыг хориглодог байна.

Энэ удаагийн ээлжит сонгуульд мандатын тоогоор буюу тус бүр нийт 78 нэр дэвшүүлж өрсөлдсөн хоёр зонхилох намаас УИХ болон бусад улс төрийн албан тушаал эрхэлж байсан 48 нэр дэвшигч өрсөлдсөн бөгөөд шинээр байгуулагдсан УИХ-д 33 нь ахин сонгогджээ. Эдгээр нэр дэвшигчийн нийгмийн сүлжээнд сонгуулийн сурталчилгаа хуульд заасан хугацаанд эхлэхээс өмнөх 2 долоо хоногийн хугацаанд нийтэлсэн мэдээллийг

<sup>14</sup> South Korea, Public Official Election Act, Art 111

үзэхэд 12 нь Алдарт эхийн одон гардуулах, барилгын шав тавих гэх мэт ажил гүйцэтгэн нэр дэвшсэн тойргууддаа албан томилолтоор ажилласан байх аж. Энэ ажилд төрийн өмчийн байр, унаа, төрийн албан хаагчид гэх мэт нийтийн нөөц, эх үүсвэрийг ашигласан нь нийгмийн сүлжээнд нийтэлсэн зураг, бусад мэдээллээс харагдана. Иймд шударга сонгуулийн гол зарчим болох тэгш гараанаас өрсөлдөх нөхцөлийг хангахад чиглүүлж зохих өөрчлөлтийг хуульд тусгах нь зүйтэй.

Өмнөх ээлжит сонгууль буюу цар тахлын хүнд нөхцөлд болсон 2020 оны УИХ-ын сонгуулиар эрх баригч нам төрийн нөөц, эх үүсвэрийг захиран зарцуулах эрх мэдлээ халамж, тэтгэмжийн чанартай өргөн цар хүрээ бүхий үйл ажиллагаа хэрэгжүүлж давуу тал олж

авахад ашигласныг иргэний нийгмийн зүгээс шүүмжилж байв. Энэ асуудал 2024 оны сонгуульд ахин давтагдлаа.

УИХ-ын сонгуулийн тухай хуулийн тухайн жилийн төсөвт тусгаагүй нийгмийн халамж, хамгааллын хөтөлбөр хэрэгжүүлэх, амлалт өгөх, зарлах нь хууль бус сурталчилгаа болохыг зааж, хориглосон. Энэхүү заалтыг зөрчсөн гэж үзэх үндэслэл бүхий "Уламжлалт мал аж ахуйд тулгамдаж буй уур амьсгалын өөрчлөлтөөс шалтгаалсан сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль" -ийг Засгийн газраас 2024 оны 04 дүгээр сарын 10-ны өдөр нэн яаралтай хэлэлцүүлэхээр УИХ-д өргөн мэдүүлж<sup>15</sup>, мөн оны 04 дүгээр сарын 19-ний өдөр баталсан.

#### **Уламжлалт мал аж ахуйд тулгамдаж буй уур амьсгалын өөрчлөлтөөс шалтгаалсан сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль**

Хуулийн төслийн танилцуулгад дэлхийн дулаарал, байгаль цаг уурын өөрчлөлт нь уламжлалт мал аж ахуйд хор хохирол дагуулж байгаа талаар дурдсан боловч энэхүү нөхцөл байдал нь үндэсний эдийн засгийн аюулгүй байдлыг хангахтай ямар холбоотой, хуулийн төсөлд олон нийтийн санал авах хугацааг хүлээх бололцоогүй ямар нэн яаралтай нөхцөл байдал үүссэн талаар огт дурдаагүй байв.

Тэрчлэн уг хуулийн 6.1.2 – 6.1.5 дахь заалтад малчны амьжиргааг дэмжих, хоршоо байгуулах, хоршоонд элсэх санаачилгыг дэмжих, уг хоршооны хөрөнгө оруулалтад шаардагдах эх үүсвэрт дэмжлэг үзүүлэх гэх мэт олон арга хэмжээг тусгасны зэрэгцээ 6.1.7-д зааснаар жилийн батлагдсан төсвийн нийт зарлагын хэмжээг нэмэгдүүлэхгүйгээр төсөв хооронд, төсвийн ерөнхийлөн захирагч хооронд, хөрөнгийн болон урсгал зардал хооронд төсвийн зохицуулалт хийх бүрэн эрхийг Засгийн газарт олгожээ. Мөн Засгийн газар эдгээр арга хэмжээг хэрэгжүүлэхэд Төсвийн тухай, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль болон бусад хуульд заасныг дагаж мөрдөхгүй буюу энэ хуулийг дагаж мөрдөх зохицуулалт тусгасан байна.

УИХ-ын ээлжит сонгуулийн цаг үетэй давхцуулан баталсан энэ хуулийг урьдчилан тооцох бололцоогүй, үндэсний эдийн засгийн аюулгүй байдал зөрчигдөж болзошгүй ямар нөхцөл байдал үүссэн учир ийнхүү нэн яаралтай горимоор хэлэлцэн баталсан нь бүрхэг төдийгүй уг хуулийн хэрэгжилтийн хүрээнд хэдий хэмжээний дэмжлэг урамшууллыг ямар шат дараалалтай олгосон талаарх мэдээ баримт дутмаг байна.

Эх сурвалж: О. Мөнхцэцэг, С. Билгүүн. Хууль тогтоомжийг олон нийтийн хэлэлцүүлэггүйгээр хэлэлцэн батлах зохицуулалт, анхаарах асуудал ННФ-ын Бодлогын асуудал №48. 2024 он.

Дээрх хуулийн хүрээнд "Шинэ хоршоо" санаачилгыг орон даяар сурталчилж, төрийн албан хаагчдыг дайчлан малчдад мэдээлэл

өгөх ажлыг зохион байгуулсан. 2024 оны 10-р сард энэхүү санаачилгад зарцуулсан хөрөнгийн талаар Засгийн газрын албан

<sup>15</sup> Хуулийн төслийн танилцуулга, үзэл баримтлалыг үзэх: <https://lawforum.parliament.mn/project/566/>

тушаалтны хэвлэлд өгсөн мэдээллээс үзвэл 16,399 малчинд нийт 556 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтын зээл олгосон гэжээ.<sup>16</sup>

Цаашид сонгуульд тэгш өрсөлдөх нөхцөлийг сайжруулахын тулд төсөв, төрийн албыг сонгуулийн үйл ажиллагаанаас зааглах

## Дөрөв. Хууль сахиулах байгууллагын оролцоо

Чөлөөт сонгуульд иргэд сонгох, сонгогдох эрхээ саадгүй эдлэх боломжтой бөгөөд дарамтад өртөх айдасгүй үг хэлэх, эвлэлдэн нэгдэх, үүнд сонгуульд өрсөлдөгч талууд сонгогчдод мөрийн хөтөлбөр, улс төрийн үзэл бодол байр сууриа хүргэж таниулах, сонгогчдын хувьд ийм мэдээлэл хайх, олж авах нөхцөл бүрдсэн байх ёстой. Шударга сонгуулийн зарчмыг авч үзвэл юун түрүүнд сонгуулийн байгууллага хараат бусаар сонгуулийг зохион байгуулдаг байхын сацуу хууль сахиулах байгууллагын зүгээс сонгуульд оролцож буй өрсөлдөгч талуудад тэгш хандан сонгуулийн эрхийг хүндэтгэж хамгаалах учиртай.

Ардчилсан сонгуулийн дээрх баталгааг хангах үүднээс УИХ-ын сонгуулийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.2-д “Зөрчил болон гэмт үйлдлийнх нь явцад, эсхүл хэргийн болон зөрчлийн газарт нотлох баримттай нь баривчилснаас бусад тохиолдолд нэр дэвшигчид холбогдуулан Сонгуулийн ерөнхий хорооны зөвшөөрөлгүйгээр эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх болон зөрчил шалган шийдвэрлэх дараах ажиллагаа явуулахыг хориглоно” гээд

- эрүүгийн хариуцлагад татах буюу эрүүгийн хэрэг үүсгэх, баривчлах, цагдан хорих (35.2.1)

зохицуулалтуудыг сонгуулийн хууль тогтоомжоос гадна Төрийн албаны тухай хууль, төсвийн холбогдолтой хууль тогтоомжид нарийвчлан зааж хариуцлагыг тодорхой болгох нь зүйтэй.

- орон байр, албан тасалгаа, тээврийн хэрэгсэл болон биед нь үзлэг, нэгжлэг хийх (35.2.2)-ийг тус тус хоригложээ.

2024 оны сонгуулийн сурталчилгааны явцад сонгогдох эрхийн хуульд тодорхой заасан дээрх хамгаалалтыг давж хууль сахиулах байгууллагын зүгээс сонгуульд оролцсон эвслийн сонгуулийн штабыг хааж үзлэг хийсэн тохиолдол гарав.<sup>17</sup>

Үүнтэй төстэй асуудал 2020 оны сонгуулиар мөн гарсан бөгөөд сонгуулийн сурталчилгааны явцад зургаан нэр дэвшигчийг саатуулж цагдан хорьсныг сонгуульд хяналт тавин ажиллаж байсан иргэний нийгмийн ажиглагчид шүүмжилж байв. Цаашид хууль сахиулах байгууллагын зүгээс сонгуулийн хууль тогтоомжийг зөрчин сонгуулийг хараат бусаар удирдан зохион байгуулах чиг үүрэг бүхий бие даасан байгууллага болох СЕХ-ны зохих шийдвэр, зөвшөөрөлгүй сонгуульд оролцож буй нам, эвсэл, нэр дэвшигчдийн эрхийг хязгаарлах арга хэмжээ авахгүй байхад анхаарах нь зүйтэй. Сонгуулийн хууль тогтоомжийг зөрчсөн дээрх шиг үйлдэл гаргавал холбогдох албан тушаалтанд хариуцлага тооцдог болох нь төрийн эрх бүхий байгууллага сонгуулийн эрхийг зөрчих хандлагыг таслан зогсоож сэргийлэх хөшүүрэг болно.

<sup>16</sup> Монгол Улсын Засгийн Газрын 2024 оны 95 дугаар тогтоолоор байгуулагдсан “Шинэ хоршоо хөдөлгөөний салбар дундын уялдааг хангах Үндэсний хороо”-ны анхдугаар хуралдаан боллоо. 2024 оны 10-р сарын 24. < <https://www.gov.mn/mn/news/all/1aa84e26-1a0e-438d-a7b0-ed194b3f20ef>> Сүүлд үзсэн огноо 2025 оны 1-р сарын 25

<sup>17</sup> Цагдаагийн байгууллага нэгжлэг хийгээгүй, үзлэг явуулсан. Үндэсний эвслийн сурталчилгааны байр гэсэн хаяг байгаагүй. 2024.6.26 <https://ikon.mn/n/36fc>

## Тав. Сонгуулийн зардал

УИХ-ын сонгуулийг угтан 2023 оны 6-р сарын 17-нд УИХ-ын сонгуулийн тухай хуульд тусгасан нэмэлт, өөрчлөлтийн үзэл баримтлалд дурдсан нэг зорилго нь сонгуулийн зардлыг бууруулахад чиглэж байв.<sup>18</sup> Энэ зорилгын хүрээнд нэр дэвшигчдийн сонгуулийн сурталчилгаанд үзүүлэх төрийн шууд бус дэмжлэгийн хэлбэр нэмэгдсэн нь чухал дэвшил болсныг тэмдэглэх нь зүйтэй. Тодруулбал хуулийн 42.1-д “Тойрогт нэр дэвшигчдийн зурагт хуудсыг байрлуулсан нэгдсэн самбар /цаашид “нэгдсэн самбар” гэх/-ыг сум, дүүргийн Засаг дарга дараах шаардлагын дагуу бэлтгэж, байршуулах ажлыг зохион байгуулна” гэж заасан нь нэр дэвшигчдийн зардалд үлэмж хэмжээ эзэлдэг хөдөлгөөнт самбарын зардлыг хэмнэх боломж нээсэн билээ.


Үндэсний аудитын газар (ҮАГ)-аас 2024 оны 1-р сарын 25-нд зардлын дээд хэмжээг тогтоох аргачлалыг баталж энэхүү аргачлалын дагуу зардлын дээд хэмжээг нэр дэвшигчийн

хувьд 890 саяас 1,5 тэрбум төгрөг, нам, эвслийн хувьд 260-659 сая төгрөг байхаар тогтоосон билээ.<sup>19</sup> Энэхүү зардлын дээд хэмжээ 2020 оны сонгуультай харьцуулахад нэлээд өссөн бөгөөд тойргийн нутаг дэвсгэр болон сонгогчийн тоо нь өөрчлөгдөөгүй тойргуудад нэр дэвшигчийн зардлын дээд хэмжээ 500 орчим саяар нэмэгдсэн байв. Тодруулбал, Баян-Өлгий аймгийн хувьд 405 сая төгрөгөөс 1 тэрбум гаруй төгрөг болсон бол Хан-Уул дүүргийн хувьд 672 сая төгрөгөөс 1,1 тэрбум төгрөг болж нэмэгджээ. УИХ-ын сонгуулийн тухай хуульд шинээр тусгасан нэгдсэн самбартай болох, ухуулагчийн тоог бууруулах гэх мэт зардлыг бууруулахад чиглэсэн арга хэмжээ төдийлөн нөлөө үзүүлээгүй нь эндээс харагдах ба цаашид сонгуулийн зардлын хэмжээг тооцох аргачлалыг сайжруулах, хуулийн зохицуулалтыг илүү нарийвчлах шаардлагатай байна.

<sup>18</sup> Сонгуулийн зардлыг 48 хувь бууруулна гэв. 2023.4.15. <https://news.mn/r/2640685/>

<sup>19</sup> Үндэсний аудитын газар. 2024.1.24 <https://audit.mn/?p=25479>





Сонгуулийн дараа Үндэсний аудитын газарт 16 нам, 2 эвсэл, 820 нэр дэвшигч хуульд заасан хугацаанд сонгуулийн зардлын тайлангаа ирүүлсэн мэдээллээс үзэхэд нийт зардлын дүн 108,515,500.0 сая төгрөг байна. Үүнийг 2020 оны дүнтэй харьцуулахад дорвитой буурсан дүн харагдахгүй байна. 2020 оны ээлжит сонгуулийн нийт зардал 76,839.6 сая, үүнээс нэр дэвшигчид 67,260.0 сая, нам, эвсэл 9,579.6 сая төгрөг

зарцуулснаа тайлагнаж байжээ. Ерөнхийд нь авч үзвэл нэр дэвшигч дунджаар 130 сая төгрөг зарцуулсан дүнтэй байв.

Харин энэ удаагийн сонгуулийн хувьд тойрогт нэр дэвшигчдийн зардлын дансны нийт орлого нь 93,620.3 сая, зарлага 93,574.5 сая төгрөг байх ба зардлын 69.7 хувь нь сонгуулийн штаб ажиллуулахад гарсан зардал байна. Нэг дэвшигчид ногдох зардлын дундаж нь 114,115,244 төгрөг байна.

Энд инфляцыг тооцоолоогүй боловч хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахад бодлого боловсруулагчдын зүгээс тооцоолон амлаж байсанчлан сонгуулийн зардал 50 орчим хувиар буураагүй байна.

Сонгуулийн зардал ийнхүү тогтмол олон тэрбумаар өсөх хандлага буурахгүй байгаа нь сонгогдох эрхийн хэрэгжилтэд таатай нөлөө үзүүлэхгүй нь тодорхой юм.

Монголын улс төрийн намуудын (ялангуяа УИХ-д суудалгүй намууд) хувьд сонгуулийн санхүүжилт босгох нь бэрхшээлтэй асуудал байсаар ирсэн бөгөөд сонгуульд нэр дэвшигчдийн хувьд кампанит ажлын санхүүжилтээ өөрсдөө хариуцаад зогсохгүй, намаа санхүүжүүлэхэд гол үүрэг гүйцэтгэж ирсэн нь өнөөг хүртэл өөрчлөгдөхгүй байна. Энэ нь сонгуулийн тэгш гарааны зарчмыг алдагдуулахын зэрэгцээ улс төрд мөнгөний зүй бус нөлөө буурахгүй байх нэг шалтгаан болж байна.

Цаашид сонгогдох эрхийг баталгаажуулах, сонгуулийн тэгш гарааны зарчмыг хангах үүднээс нэр дэвшигчдээс сонгуульд зарцуулж болох зардлын дээд хэмжээг бусад ардчилсан улсын жишгээр хуульд заасан хандивын дээд хязгаартай уялдуулан тогтоох нь зүйтэй. Жишээ нь, Канад Улсын сонгуулийн хуулийг үзэхэд нэр дэвшигч өөрийн хөрөнгөөс хамгийн ихдээ 5000 канад доллар зарцуулж болно гэж заажээ.<sup>20</sup>

Одоогийн байдлаар УИХ-ын сонгуулийн тухай хуулийн 49.2.3-д нэр дэвшигчийн өөрийн хөрөнгийг сонгуульд зарж болохоор зохицуулсан боловч дээд хэмжээ заагаагүй байна. Жагсаалтаар нэр дэвшигчдийн хувьд хуулийн 53.4.д зааснаар “нам, эвслийн сонгуулийн сурталчилгаанд зориулан хандив өгч болох бөгөөд нэг нэр дэвшигчийн өгсөн

хандивын хэмжээ нь энэ хуульд заасны дагуу тогтоосон нэр дэвшигчээс тойрогт зарцуулах зардлын хэмжээний дунджаас хэтрэхгүй байна гэж зохицуулсан нь мөн сонгогдох эрхэд халтай байгааг анхаарах нь зүйтэй.

Төрийн аудитын байгууллагаас тогтоосон 2024 оны ээлжит сонгуулиар тойрогт нэр дэвшигчээс зарцуулах зардлын дээд хэмжээнд үндэслэн тооцвол жагсаалтаар нэр дэвшигч намдаа 1,135,805,935.53 төгрөг “хандив” нэрийн доор шилжүүлж болохоор байна. Үндэсний аудитын газраас нийтэд мэдээлсэн сонгуулийн зардлын тайлангийн мэдээллээс үзэхэд 1,135,000,000 төгрөгийн “хандив” шилжүүлсэн нэр дэвшигч нэг байгаа бол 400,000,000 төгрөгөөс дээш дүнтэй “хандив” шилжүүлсэн гурван нэр дэвшигч 975,000,000 төгрөг, 574,100,000 төгрөг, 400,000,000 төгрөг тус тус шилжүүлжээ.

Түүнчлэн жагсаалтаар нэр дэвшигчдийн хувьд дээрх “хандив”-ыг сонгогч дэмжигчдээсээ хандив байдлаар бүрдүүлэх боломж сонгуулийн хуулиар олгоогүй нь анхаарал татаж байна.

Сонгуулийн зардлын дансыг зөвхөн нам, эвсэл болон тойрогт нэр дэвшигч сонгуульд оролцуулахаар бүртгэх тухай шийдвэр гарснаас хойш нээн ашиглах бололцоотой байхаар зохицуулсан байдаг. Энэ зохицуулалтын хүрээнд жагсаалтаар нэр дэвшигч зардлын данс нээх бололцоогүй бөгөөд тойрогт нэр дэвшигчдийн хувьд хуулийн дагуу мөнгө босгож, зарцуулах хугацаа нь нэг сар орчим байхаар байна. Сонгуулийн сурталчилгааны цаг зав хомс үед ийнхүү мөнгө босгож сурталчилгаатай холбоотой зардлаа санхүүжүүлэх нь хэрэгжүүлэхэд нэн төвөгтэй зохицуулалт болох нь ойлгомжтой ба хуулиас гадуур аргаар

<sup>20</sup> <https://laws-lois.justice.gc.ca/eng/acts/e-2.01/page-41.html>



кампанит ажлаа санхүүжүүлэх нэг сэдэл болохыг үгүйсгэх аргагүй.

Зардлын тайлантай холбоотой анхаарал татсаар ирсэн бас нэг асуудал нь сонгуульд өрсөлдөгч талуудын өр болон дансны үлдэгдлийн асуудал юм. 2024 оны ээлжит сонгуулиар нэр дэвшигчдийн зардлын тайланд туссан өглөгийг авч үзвэл 471.2 сая төгрөгийн мөнгөн хөрөнгийн, 17.4 сая төгрөгийн бараа материалын өглөгтэй байжээ.<sup>21</sup> Нам, эвслүүдийн хувьд 2,191.8 сая төгрөгийн өглөгийг тайландаа тусган мэдээлсэн байна.


Сонгуулийн хууль тогтоомжид сонгуулийн зардлын дансны үлдэгдэл хөрөнгө болоод төлөгдөөгүй зардлыг тодорхой үе шаттай тайлагнах талаар зохицуулалт дутагдалтай. Сонгуулийн дараа нам, нэр дэвшигчид нэлээд хэмжээний өр, зээлтэй үлдэх нь байнга тохиолдсоор ирсэн асуудал атал энэ өр, зээлийг хэрхэн, ямар эх үүсвэрээс санхүүжүүлэн барагдуулсан талаар мэдээллийг олон нийтэд ил болгох зохицуулалт байхгүй байсаар өнөөг хүржээ.

Үүнээс гадна нэр дэвшигчдийн зардлын дансанд цугласан хандивын үлдэгдлийг хэрхэх тухай зохицуулалт мөн дутмаг байна. Канад Улсад нам, эвслээс нэр дэвшигчид сонгуулийн зорилгоор цуглуулсан хандивын үлдэгдлийг намынхаа данс руу шилжүүлэх, бие даан нэр дэвшигчид нь сонгуулийн төв байгууллагадаа шилжүүлэх хуультай. Хуулийн ийм зохицуулалт нь сонгуулийг ашиглаж мөнгө угаах эрсдэлээс сэргийлэх давхар ач холбогдолтой байж болох юм.

Сонгуулийн зардлын тайлантай холбоотой бас нэг анхаарал татаж ирсэн асуудал нь УАГ-т албан ёсоор тайлагнаж буй дүнгээс гадна ямар хэмжээний орлого, зардлыг сонгуульд

оролцогч талууд тайлагнахгүй байна вэ гэдэг асуулт юм.

2024 оны сонгуулиар нийгмийн сүлжээнд цацагдсан сонгуулийн сурталчилгааг хянасан FactCheck.mn мэдээлснээс үзэхэд “1,000 ам.доллороос дээш дүнтэй ам.доллар төлж сонгуулийн утгатай пост түгээсэн, намын албан ёсны бус 11 пэйж хаягийг нягталж үзэхэд 2 нь ХҮН намыг, 9 нь МАН-ыг дэмжсэн агуулгуудыг нийтэлжээ. Эдгээр 11 пэйж 64,337 ам.долларыг Метад төлсөн бөгөөд үүний 54,285 ам.доллар буюу 84.3% нь МАН-ыг дэмжсэн постод зарцуулагдсан байна” гэжээ.



Эх сурвалж: factcheck.mn

Сонгуулийн хууль тогтоомжид сонгуульд оролцохоор бүртгүүлсэн нам, эвсэл, нэр дэвшигчдээс гадна сонгуулийн сурталчилгаанд зардал гаргаж буй гуравдагч этгээдийн санхүүжилтийг огт зохицуулаагүй орхигдуулсан. Гэтэл ийм сурталчилгаа нэмэгдэх хандлага 2020 болон 2024 оны ээлжит сонгуулиудаас ажиглагдаж буйг анхаарч зохих зохицуулалтыг хуульд тусган нийтэд ил тод мэдээлэх нь чөлөөт, шударга сонгуулийн зарчимд нийцнэ.

<sup>21</sup> Үүнийг 2020 оны сонгуулийн үзүүлэлттэй харьцуулж үзвэл нэр дэвшигчид нийт 1.3 тэрбум төгрөгийн төлөгдөөгүй зардал тайлагнасан байх ба зардлын дансны үлдэгдэл хөрөнгийг авч үзвэл 856 орчим сая төгрөг байжээ. Нам эвслийн хувьд төлөгдөөгүй зардлын дүн нь мөн 1.3 тэрбум төгрөг байсан ажээ.

Хариуцагч	Зарцуулсан мөнгө (\$)	Сурталчилгааны тоо
Ард түмний ялалт	24715	73
Ган үзэгтэн ХХК	7781	73
Нада	7060	20
Бид ардчиллынхан	6882	29
Мэдээллийн ажилтан	5742	111
Алдагдсан 12 жил	4199	19
Нийслэл хуудас	3336	14
48	3198	9
126к	2992	12
АН-ыг үнэнчээр дэмжигчид	2291	25
Шударга шуугиан	2288	24
Улсаа зарахгүй шударга иргэдийн хөдөлгөөн	1634	19

Эх сурвалж: factcheck.mn <https://factcheck.mn/post/8505>

### Сонгуулийн үйл явцын ил тод байдал, иргэний нийгмийн хяналт

Ардчилсан сонгуулийн нэг гол зарчим нь сонгуулийн үйл явцын ил тод байдал бөгөөд сонгуульд иргэний нийгмийн зүгээс идэвхтэй хяналт тавих нь сонгуулийн үйл явц, үр дүнд итгэх олон нийтийн итгэлийг нэмэгдүүлж аливаа маргаан, зөрчил гарахаас урьдчилан сэргийлэхэд чухал ач холбогдолтой билээ.



Энэ удаагийн сонгуульд Шударга сонгуулийн төлөө иргэний нийгмийн хяналт сүлжээний гишүүн байгууллагууд дараах хэд хэдэн чиглэлээр мониторинг хийлээ. Үүнд: Глоб Интернэшнл ТББ хэвлэл мэдээлэлд, МИДАС ТББ сонгуулийн автоматжуулсан системд болон сонгогчдын нэрийн жагсаалтад, Бодлогод залуусын хяналт ТББ

сонгуулийн кампанит ажлын санхүүжилтийн мониторингийг тус тус хийж гүйцэтгэлээ.

Тэрчлэн, сонгуулийн өдөр сүлжээний 240 ажиглагч сонгуулийн санал хураах, тоолох, дүнг гаргах үйл явц болон хяналтын гар тооллого хийх үйл явц сонгуулийн хууль тогтоомжийн дагуу явагдаж буй эсэхэд хяналт тавьж ажилласан билээ. Ажиглагчдыг зохион байгуулах, мэдээллийг нэгтгэх, шаардлагатай үед шуурхай арга хэмжээ авах үүрэгтэй 20 багийн ахлагч, зохицуулагч сонгуулийн өдөр 24 цагийн турш тасралтгүй ажиллав. Ажиглалт нь Улаанбаатар хотод байршилтай 100 хэсгийн хороо, 11 аймгийн 12 хэсэгт нийт 112 хэсгийн хороог хамарсан болно. Эдгээр

ажиглалт, мониторингийн үр дүнг [www.sanal.mn](http://www.sanal.mn) цахим хуудаснаас дэлгэрүүлэн үзэх боломжтой.

Иргэний нийгмийн байгууллагууд 2008 оноос өмнөх сонгуулиудад хяналт тавихад төрийн байгууллагуудын мэдээлэл нууцлах хандлага гол саад болдог байв. 2011 онд Мэдээллийн ил тод байдлын тухай хууль батлагдсанаар ийм бэрхшээл гарах нь харьцангуй багасаж ил тод байдал мэдэгдэхүйц сайжраад байв. Гэтэл 2024 онд төрийн зарим байгууллагын зүгээс хуулийн хүрээнд нээлттэй байх ёстой мэдээллийг сонгуульд хяналт тавин ажилласан иргэний нийгмийн байгууллагад өгөхөөс татгалзаж ухралт гарав.



Төрийн байгууллагуудын зүгээс сонгуулийн ил тод байдлын зарчмыг үл хүндэтгэн хууль зөрчсөн үйлдэл гаргаж байгаа нь ардчилсан сонгуулийн үнэт зүйлийг бэхжүүлэхэд гарч ирсэн ололт амжилтыг ухраах хор уршигтай. Иймд хууль зөрчсөн албан тушаалтнуудад зохих хуулийн хүрээнд хариуцлага тооцох нь зүйтэй.

## Дүгнэлт

Сонгуулийн супер цикл тохиосон 2024 онд дэлхий дахинаа 74 улсад үндэсний хэмжээний сонгууль болж, 1.6 тэрбум сонгогч саналаа өгчээ. Үүний нэг нь 2024 оны 6-р сарын 28-нд болсон Монгол Улсын Их Хурал (УИХ)-ын 9 дэх удаагийн ээлжит сонгууль байв. Энэ удаагийн ээлжит сонгуулиар 126 гишүүнтэй анхны парламентыг бүрдүүлсэн нь орчин цагийн улс төрийн түүхэнд тодоор тэмдэглэх онцлог үйл явдал байлаа.

Манай улс ардчиллын замыг тууштай сонгон бэхжүүлэхээр хичээнгүйлэн чармайсан гуч гаруй жилийн хугацаанд сонгуулийн эрх зүйн орчныг боловсронгуй болгоход чамлахааргүй өөрчлөлтүүд гарч ирсэн билээ. Гэвч чөлөөт, шударга сонгуулийн зарчмуудыг тууштай хэрэгжүүлэхэд зарим бэрхшээл тохиолдсоор байгаа нь 2024 оны УИХ-ын ээлжит сонгуулийн явцад тохиолдсон зарим үйл явдлаас тодорхой байна. Эдгээр үйл явдлуудыг нэгтгэн, тэдгээрт хамаарах эрх зүйн орчинд хийсэн дүн шинжилгээний хамт энэхүү ерөнхий тоймд тусгасан болно. Тоймд тусаагүй боловч сонгуулийн эрх зүйн орчныг сайжруулах хүрээнд зайлшгүй авч үзэх шаардлагатай сонгогчдыг бүртгэл, гадаадад байгаа сонгогчдын оролцоог сайжруулах, үүнд цахим технологийг ашиглах гэх мэт асуудал байгааг дурдах нь зүйтэй.

Тоймд авч үзсэн асуудлын хүрээнд дараах арга хэмжээг авах нь зүйтэй хэмээн зөвлөж байна. Үүнд:

- Сонгуулийн тогтолцооны тогтвортой байдлыг хангаж тойргуудыг сонгууль бүрээр шинээр байгуулдаг зохицуулалтыг халах, улмаар тойрог байгуулах, мандат хуваарилах үйл явцыг ардчилсан сонгуулийн нэг сонгогч-нэг санал- нэг үнэ цэн зарчимд нийцүүлэн мэргэжлийн байгууллагуудын оролцоотой, ил тод шийдвэрлэдэг болох,
- Сонгуульд өрсөлдөгч талууд тэгш гараанаас өрсөлдөх нөхцөлийг бүрдүүлэх, сонгуулийн кампанит ажлын хугацааг зохистой тогтоох, УИХ-ын гишүүд болон эрх баригчид төрийн эх үүсвэрийг ашиглахад хариуцлага тооцох зохицуулалтыг боловсронгуй болгох, таслан зогсоох үр дүнтэй хөшүүрэг хуульд тодорхой тусгах,
- Сонгогч саналаа чөлөөтэй гаргах эрхийг ханган мандатын тооноос цөөн санал тэмдэглэсэн саналыг хуудсыг хүчингүйд тооцох хуулийн заалтыг өөрчлөх,
- Нэр дэвшигчдэд болон сонгуульд оролцох нам, эвсэлд тавих шаардлагыг сонгох эрхийг хангах зарчимд нийцүүлэн шинэчлэх,
- Хууль сахиулах байгууллагын зүгээс сонгуульд өрсөлдөгч талуудтай холбоотой зөрчил болон хэрэг хянан шийдвэрлэх үйл ажиллагаа, үзлэг нэгжлэг хийх бол зөвхөн СЕХ-ны зөвшөөрлийн үндсэн дээр хийх асуудлыг холбогдох хуулиудад ойлгомжтой тусгах,
- Сонгуулийн санхүүжилттэй холбоотой харилцааг нам, эвсэл, нэр дэвшигч хөрөнгө босгохоос эхлээд цогцоор нь цаг хугацааны хувьд бодитой хэрэгжих боломжтой байдлаар зохицуулах, үүнд сонгуулийн санхүүжилтийг 2023 оны Улс төрийн намын хуультай нийцүүлэн нэр дэвшигчээс гаргаж болох хөрөнгө, хуулийн этгээд, тэдгээрийн салбар болон охин компаниас нийлбэр дүнгээр өгч болох

хандив, өр зээлийн төлбөрийг тайлагнах  
гэх мэт зохицуулагдаагүй асуудлыг хуульд  
тусгах,

- Сонгуулийн үйл явцад сайн дураар хяналт  
тавин ил тод байдлыг хангах үүргээ  
гүйцэтгэж буй төрийн бус байгууллагуудад

төрийн байгууллагуудын зүгээс хуулийн  
хүрээнд шаардлагатай мэдээллийг саадгүй  
гарган өгч дэмжлэг үзүүлдэг болох,  
хууль зөрчин мэдээлэл гаргаж өгөхөөс  
үндэслэлгүй татгалзсан албан тушаалтанд  
хариуцлага хүлээлгэдэг болох.